

Та ажлын карттай, хөдөлмөрийн гэрээ байгуулж мөн ажил олгогч танаас ИТГЭМЖЛЭЛД гарын үсэг зурахыг хүсэж байна уу?

!АНХААР!

Ажлын карт нь ажиллах зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн нэг төрөл юм.

ТА АЖЛЫН КАРТАА СУНГАХ БОЛОМЖТОЙ. ТА АЖЛЫН КАРТ СУНГАХ ӨРГӨДЛИЙГ ӨӨРИЙН БИЕЭР МЭДЭГДЭХ БА ТАНЫГ ӨӨР ХҮН ТӨЛӨӨЛӨХ ЁСГҮЙ! Ажлын картыг сунгах өргөдөл гаргахдаа та Дотоод хэргийн яамны ОАМР захиргааны хураамж болох 2500 кроны маркаар төлнө. Та сунгалт хийхдээ хэн нэгэнд нэмэлт өөр төлбөр төлөх шаардлагагүй.

ХЭРВЭЭ АЖИЛ ОЛГОГЧ (эсвэл өөр хэн нэгэн) таны өмнөөс оршин суух асуудлыг зохицуулна гэж хэлээд гарын үсэг зурах бүрэн эрхээ САНАЛ БОЛГОСОН бол ТА ЭНЭ БИЧИГ БАРИМТАД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЁСГҮЙ. ОЙЛГОХГҮЙ ЗҮЙЛДЭЭ БҮҮ ГАРЫН ҮСЭГ ЗУР, ӨӨРИЙГӨӨ БИТГИЙ АЙЛГААРАЙ. Оршин суух эрхийн бүх асуудлыг өөрөө үнэ төлбөргүй шийдэж болно.

Итгэмжлэл гэдэг нь таны оролцоогүйгээр өөр хүн таны өмнөөс аливаа асуудлыг шийдвэрлэх боломжийг олгодог баримт бичиг юм. Итгэмжлэлийг бичгээр эсвэл протоколд амаар өгч болно. Итгэмжлэл нь олгогч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, авах арга хэмжээний талаарх мэдээлэл, хүчинтэй байх хугацаа зэргийг агуулсан байх ёстой.

- **Төлөөлөгч** – таныг төлөөлөх боломжийг олж авсан хүн
- **Олгогч** – та өөрөө буюу таны оролцоогүйгээр өөр хүнд таны өмнөөс үйл ажиллагаа явуулах боломжийг олгосон хүн юм

АНХААРУУЛГА - Ерөнхий итгэмжлэлээр та аль ч байгууллагад бүх асуудлаар төлөөлүүлэх боломжтой. Хэрэв та ерөнхий итгэмжлэл олгох бол хэн нэгэн танд мэдэгдэлгүйгээр энэ баримт бичгийг ашиглан таны өмнөөс үйл ажиллагаа явуулах тохиолдол гарч болзошгүй. Хэрэв та зөвхөн тодорхой үйлдэл, журмын төлөө итгэмжлэл олгосон бол энэ нь **тусгай итгэмжлэл** юм.

Хэрэв та гарын үсэг зурж итгэмжлэл олгосон эсэхээ мэдэхгүй байгаа бол "өргөдөл шалгах хүсэлт"-ээр дамжуулан ажлын карттайгаа холбоотой мэдээллийг Дотоод хэргийн яамны ОАМР-д хандаж хүсэлт гаргах боломжтой. Хэрэв та ажил олгогчдоо болон өөр хэн нэгэнд итгэмжлэл өгсөн бол энэ тухай мэдээллийг эндээс авах боломжтой.

ХЭРВЭЭ ТА ИТГЭЛЧЛЭЛ ӨГСӨН, ТЭГЭЭД ТА ӨӨРИЙГӨӨ ТӨЛӨӨЛӨХ ТАЛААР БОДЛОО ӨӨРЧЛЭСЭН БОЛ ИТГЭЛЧЛЭЛЭЭ ЦУЦЛАЖ БОЛНО:

- Төлөөлөгчийн (төлөөлөгч) талаас: Итгэмжлэлийг дуусгавар болгох
- Олгогчийн (төлөөлсөн) талаас: Итгэмжлэлийг хүчингүй болгох

Итгэмжлэлийг хүчингүй болгоход тавигдах шаардлага: Итгэмжлэлийг хүчингүй болгох нь итгэмжлэлтэй ижил шаардлага тавина. Итгэмжлэлийг баталгаажуулах болон хүчингүй үед гарын үсэг албан ёсоор баталгаажуулсан байх шаардлагатай (жишээлбэл, ерөнхий итгэмжлэлийг захиргааны журмаар олгосон бол түүнийг хүчингүй болгосон тухай гарын үсгийг мөн албан ёсоор баталгаажуулах ёстой, өөрөөр болохгүй).



FINANCOVÁNO
EVROPSKOU UNÍÍ
AZYLOVÝ, MIGRAČNÍ
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financováno Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.

Та ажлын карттай, хөдөлмөрийн гэрээ байгуулж мөн ажил олгогч танаас ИТГЭМЖЛЭЛД гарын үсэг зурахыг хүсэж байна уу?

!АНХААР!

Итгэмжлэлийг хүчингүй болгох журам:

1. **Итгэмжлэлийг хүчингүй болгох эхний алхам бол тодорхой итгэмжлэлд хамаарах бүх өгөгдлийг олж мэдэх (эсвэл бэлэн болгох) юм (энэ нь бичгээр өгсөн итгэмжлэл эсвэл аман хэлбэрээр олгосон итгэмжлэл эсэх тухай мэдээлэл, мөн ерөнхий итгэмжлэл үү эсвэл тусгай итгэмжлэлийн тухай эсэх, итгэмжлэгдсэн төлөөлөгч, итгэмжлэгчийн тухай мэдээлэл, итгэмжлэлийн хамрах хүрээ болон авах арга хэмжээний тухай мэдээлэл, хүчинтэй байх хугацаа, итгэмжлэл олгосон огноо).** Хэрэв та бичгээр итгэмжлэл хийсэн бол түүнийг хүчингүй болгоход бэлэн байлгахад хялбар. Хэрэв танд итгэмжлэл байхгүй бөгөөд энэ талаарх дээр дурдсан мэдээллийг мэдэхгүй бол та үүнийг Дотоод хэргийн яамны ОАМР-д хадгалагдаж буй таны оршин суух өргөдлийнтэй холбоотой баримт бичгээс олох болно. Баримт бичгийг үзэхийн тулд (итгэмжлэлийн мэдээллийн зургийг авах боломжтой) та Дотоод хэргийн яамны ОАМР-гээс бичгээр хүсэлт гаргах ёстой. Хэрэв танд өргөдөл бичихэд тусламж хэрэгтэй бол РПИ ажилтнуудтай холбогдоно уу.
2. **Хэрэв та итгэмжлэлийн тухай мэдээллийг үндэслэн бичгээр итгэмжлэл олгосон бол итгэмжлэлийг хүчингүй болгосон тухай бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгч (төлөөлсөн) болон ОАМР MVČR-д хүргүүлнэ. Дотоод хэргийн яамны ОАМР-ийн тухайд итгэмжлэлийг хүчингүй болгох нь зөвхөн түүнд мэдэгдсэн үеэс л хамаарна.** Итгэмжлэлийг хүчингүй болгох тухай Дотоод хэргийн яамны ОАМР-д мэдэгдэх хүртэл баримт бичгийг итгэмжлэгдсэн төлөөлөгч рүү мэдэгдэнэ. Хэрэв танд өргөдөл бичихэд тусламж хэрэгтэй бол РПИ ажилтнуудтай холбогдоно уу.
3. **Хэрэв та протоколд итгэмжлэл олгосон бол Дотоод хэргийн яамны ОАМР-д хадгалагдаж буй энэхүү протоколд итгэмжлэлээ цуцалж байгаагаа мэдэгдэж баримт бичгийн нэг хэсэг болгоно. Үүний зэрэгцээ эрх бүхий этгээдэд (төлөөлөгчид) энэ талаар мэдэгдэх нь зүйтэй.**

Хэрэв итгэмжлэлийг тодорхой хугацаанд олгосон бол төлөөлөгчийн итгэмжлэлд үндэслэсэн төлөөлөл энэ тухайн хугацаагаар дуусгавар болно.

Хэрэв та тодорхой үйлдэлд итгэмжлэл хийж гарын үсэг зурсан бөгөөд ижил итгэмжлэл шинэ төлөөлөгчид хийвэл яах вэ? Өөр итгэмжлэл бичээд анхны итгэмжлэл хүчингүй болно. Та итгэмжлэл бүрд зөвхөн нэг төлөөлөгчтэй байх боломжтой.

**ТӨЛБӨРӨӨ ТӨЛӨХ
ШААРДЛАГАГҮЙ ҮЙЛДЭЛД БҮҮ
ТӨЛБӨР ТӨЛ.** Хэрэв танд ямар нэгэн зүйлд тусламж хэрэгтэй бол бидэнтэй холбоо барина уу. **Бид танд ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ туслахдаа баяртай байх болно.**



Poradna pro integraci, z. ú.
Centrum na podporu integrace cizinců
v Ústeckém kraji
Tel.: +420 475 216 536, E-mail: usti@p-p-i.cz
Web: www.centrumcizincu.cz
FB: Poradna pro integraci Ústí nad Labem
<https://www.facebook.com/ppiusti>



FINANCOVÁNO
EVROPSKOU UNÍÍ
AZYLOVÝ, MIGRAČNÍ
A INTEGRAČNÍ FOND



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" AMIF/31/03 je financován Evropskou unií v rámci národního programu Azylového, migračního a integračního fondu a rozpočtu Ministerstva vnitra České republiky.